

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“ДЦС-3” ТӨХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Үнсний 3 дугаар шугам их засвар** хийх ажлыг гүйцэтгэх тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 10.00 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 10.30-д** цахим системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: тооцно  
Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,  
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Соёлын төв, 2 давхар  
Засвар хяналтын алба: Утас: 70111315, Факс: 976-343024.  
Веб хуудас: [www.tes3.energy.mn](http://www.tes3.energy.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 1 <i>жилийн</i> жилийн санхүүгийн тайлан</li> <li>- Сүүлийн 2 <i>жилийн</i> туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</li> <li>- Татварын тодорхойлолт (цахим)</li> <li>- Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, төсөв</li> <li>- Компанийн болон НӨАТ-н гэрчилгээний хуулбар, компанийн товч танилцуулга, ажиллах хүчний мэдээлэл тус тус хавсаргана.</li> <li>- Шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл болон 5 тонноос багагүй кран, цахилгаан үүсгүүртэй гагнуурын аппарат /сак/-ны мэдээлэл ирүүлэх.</li> <li>- Дараах тусгай зөвшөөрлүүдийн нэгээс доошгүй зөвшөөрөл байх шаардлагатай</li> </ul> <p><i>Эрчим хүчний яам:</i></p> <p><u>03.3.1.</u> <i>115-250°C температуртай, 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар</i></p> <p><u>03.4.1.</u> <i>115-250°C температуртай, 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай даралтат савны угсралт, засвар</i></p> <p><u>03.5.1.</u> <i>115-250°C температуртай, 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засвар</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>  <u>Огноо:</u> <i>2020оны 05-р сарын 06-ны өдөр</i>  <u>Цаг:</u> <i>10 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээлт хийх газар хугацаа нь:  Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар “Хангамжийн инженерүүд”-ийн өрөө</i>  <u>Огноо:</u> <i>2020 оны 05-р сарын 06-ны өдөр</i>  <u>Цаг:</u> <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><i>ЗХА-08. 2020 “Үнсний 3 дугаар шугам их засвар”</i></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ДДХ-ийн Үнсний 3 дугаар шугам их засварын ажил гүйцэтгэхдээ тендерийн материалын 5-р бүлэгт заагдсан ажлын эзэлхүүнд тусгагдсан бүх ажлыг бүрэн хэмжээгээр чанартай гүйцэтгэнэ. Ажлын явцад ажлын эзэлхүүнээс нэмэгдэх хасагдах зүйл гарч болно. Гарсан нэмэгдэл ажлыг магадлашгүй ажлын зардлаар хийнэ. Магадлашгүй ажлын зардал болон НӨАТ-ыг гүйцэтгэгч төсөвтөө тусгаж өгнө. Захиалагч нэмэлт ажлын төсөв зардал гэж тусдаа гаргахгүй.

Засварын ажлыг гүйцэтгэхдээ засварын технологиудыг чанд баримталж ажиллах, шаардлагатай үед ЗХА-ны мэргэжилтэнүүдтэй зөвлөлдөж тусгай технологи гаргаж түүний дагуу засварын ажил гүйцэтгэх ёстой. Дур мэдэн ямар нэг өөрчлөлт, технологи хэрэглэхгүй байх.

Захиалагч засварын технологийн мөрдөлт, засварын чанар, материал сэлбэг зарцуулалт, ажлын гүйцэтгэлд төслийн менежер болон захилагчийн мэргэжлийн инженер, мастерууд хяналт тавьж ажиллана.

### ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ТЕНДЕРИЙН ШААРДЛАГА, ТЕНДЕРИЙН НӨХЦЛҮҮД

#### 1. ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Энэхүү засварын сэлбэг, материалыг нийлүүлэх болон засварын ажлыг гэрээнд заагдсан хуанлийн 45 хоногийн хугацаанд бүрэн хэмжээгээр хийсэн байна.
2. Засварын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах хийц, эд ангиуд, тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэх ажлын хөлс, турших тохируулахад гарах зардал болон бусад зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд зардлуудыг сонгон шалгаруулалтын материалд тусгасан байвал зохино.
3. Тендерийн заавал биелүүлэх нөхцөл, тендерийн шаардлага, ХАБЭА-н шаардлагуудад шаардагдах хөрөнгийг гүйцэтгэгч хариуцахаар тусгах шаардлагатай.
4. Гүйцэтгэгч компани засварын ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.

#### 2. ЗАСВАР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

1. Засварт оролцох гүйцэтгэгч байгууллагын ажиллагсад нь Эрчим хүчний үйлдвэрт мөрдөгдөж байгаа ТАД, ААД, ГАУСД, ХАБЭА хуулийн зохих мэдлэгтэй, ээлжит шалгалт өгсөн мэргэжлийн үнэмлэхтэй байна.
2. Тухайн ажлын байранд ажиллах хүмүүс шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ХАБЭА-н хувцасаар бүрэн хангагдсан, эрүүл мэндийн үзлэгт орсон, энэ ажилд эрүүл мэндээр тэнцэх хүмүүс байна.
3. Ажлын байрыг байнга эмх цэгцтэй, хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж, шат тавцангууд болон эд ангиудыг шуурхай ажиллагаанд /ашиглалтын ажилд/ саад болохооргүй чөлөөтэй байлгах үүрэг хүлээнэ.
4. Засварт оролцох гадны байгууллагын ажиллагсад нь “ДЦС-3” ТӨХК-ийн дотоод дүрэм журам, ХАБЭА-н талаар мөрдөгдөж байгаа дүрэм, журам эдгээрийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, торгууль, шийтгэлийг мөн адил мөрдөж ажиллах үүрэгтэй.
5. Ажлын байранд галын хэсгийн зөвшөөрөлгүй, галын нарядгүйгээр гагнуурын болон галын аюултай ажил гүйцэтгэх, ил гал түлэх, тамхи татахыг хориглоно.

Тав. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Батлав. .... ХХК-ий захирал  
...../ /

ҮНСНИЙ 3 ДУГААР ШУГАМ ИХ ЗАСВАР ХИЙХ АЖЛЫН ҮНЭЛЭГДСЭН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

№	Хийгдэх ажлууд	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	БАА-н БЭН- 1, 2, 3-ыг бүрэн зогсоож ф325х10мм-тэй үнсний 3-р шугамыг усан талаас бүрэн таслуулж дренажлах.	КОМ	1			
2	БЭН-3-ын насосны шахах хаалт Ду300/25-аас далан хүртэл үнсний 3-р шугамны тулгуурууд, бэхэлгээний даруулга, боолтуудыг тайлж авах, шинээр хийх, сэргээн засварлах.	Ш	85			
3	БАА-аас далан хүртэл багана дээгүүр явсан Ф325х10мм-тэй труба хоолойг 10-15м-ийн урттай тайрах /850 м/	СТЫК	85			
4	БАА-аас далан хүртэл багана дээр 10м-ийн урттай тайрсан Ф325х10мм-тэй труба хоолойг троссоор оосорлон кранаар өргөж 6 метр тулгуур дээрээс буулгах	ТН	66			
5	Ф325х10мм-ийн 10м-ийн урттай 85ш труба хоолойн дотор талын хананд хатуурч үелэн тогтсон үнсийг гар аргаар цэвэрлэх.	М	850			
6	Далангаас цааших Ф325х10мм-тэй үнсний 3-р шугамыг / нийт 850м / хэсэгчлэн 15 метрээр тайрах	СТЫК	56			
7	Далангаас цааш тайрсан Ф325х10мм үнсний шугамын дотор хананд хатуурч үелэн тогтсон үнсийг гар аргаар цэвэрлэх	М	800			
8	Цэвэрлэсэн ф325х10 мм трубанд ирмэгийн боловсруулалт хийх	СТЫК	141			
9	Ф325х10мм-тэй 10 м-ийн урттай труба хоолойг троссоор оосорлон /Н-6м/ кранаар өргөж тулгуур дээр тавих.	ТН	66			
10	Ф325х10мм-тэй 15метр урттай труба хоолойг троссоор оосорлон /Н-0.5м/ кранаар өргөж бетонон тулгуур дээр тавих	ТН	66			
11	Ф325х10мм труба хоолойн амыг тааруулж торгоох, холбож 90° эргүүлж, 2 үе гагнах	Нийт СТЫК	1500м 141			
12	Компенсаторуудыг шугамнаас салгаж авах /Ф325х10мм/	Ш	6			

13	Салгаж авсан компенсаторыг /шинээр хийж/ засварлаж дууссаны дараа эргүүлж шугамд холбож гагнах. /Ф325х10мм/	Стык	12			
14	Компенсаторуудын сальникний шахуургийг тайлж авах, боолтнуудыг сэргээн засварлах, солих	ш	6			
15	Компенсаторуудын хуучин сальникуудыг ухаж авах, шинээр 6-8 давхар тосон /Ф16мм/ сальник тавих	ком	6			
16	Ф325х10мм-ийн шугам хоолойг тулгуур дээр нь бэхлэх хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй тулгуурууд, бэхэлгээний хийцийг хийж бэлтгэх. /швеллер Н=140мм, полоса, круг Ф12мм зургийн дагуу тайрч бэлтгэж, полоса кругийг матаж цоолж, үзүүрүүдэд резьба гаргаж М12-14 боолтоор бооход бэлтгэнэ/	ш	85			
17	Шинээр хийсэн хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй бэхэлгээнүүдийг суурин дээр байрлуулж бэхлэх, боох.	ш	85			
18	Далан дээгүүр явсан хэсгийн дэр бетонуудын хоорондох зай жигдрүүлэх, хөндийрсөн хэсэгт дэр хийж засварлах, хязгаарлагч шинээр хийх	ш	48			
19	Шугам хоолойг өргөх, буулгах ажилд автокран ажиллуулах	Мот/цаг	94			
20	Шугам хоолойг гагнах сак ажиллуулах	Мот/цаг	141			
21	Эргүүлсэн болон сольсон хэсгийг будах, тэмдэглэгээ хийх.	М2	204			
22	Автокран ажиллуулах шатахуун / солярка / авч бэлтгэх	л	883			
23	САК ажиллуулах /бензин, солярка/ бэлтгэх	л	846			
24	Ф325х10мм-ийн шугаманд ф108х4мм-ийн трубагаар хамгийн нам цэгүүдэд дренаж хийх	ш	6			
25	Ф108х4мм-ийн хоолойд тааруулж б=20мм-н листээр зургийн дагуу фланц бэлтгэх	хос	6			
26	Дренажийн шугаманд фланц тааруулж гагнах	ш	6			
27	Тааруулж гагнасан фланцандаа жийрэг тавьж боох	ш	6			
28	Үнс шааргийг цэвэрлэсний дараа хананы зузааныг шалгаж труба /Ф325х10мм/ хоолойг хэсэгчлэн солих, /хонхойсон, нимгэрсэн /	м/тн	55/4,7			
29	Засварын ажил дууссаны дараа шугамыг усаар үлээлгэж цэвэрлэх, дернажууд онгойлгож юүлэх. Ус тогтсон байгаа хэсгүүдэд нэмэлт дренаж хийх.	ком	1			
30	Шинээр үнсэн сан барьж байгаатай холбогдуулан үнсний 2,3-р шугамыг / 110мх2=220м / хуучин байрнаас нь 3м зайд хажуу талруу нь зөөж байрлуулах, гагнах. Булан 120° - 4ш	м тн булан	110*2=220 17 4ш			
31	Үнсний 2,3-р шугамыг шинээр зөөж байрлуулах хэсэгт швеллер Н=140мм-ээр 500мм өндөр тулгуур гагнаж, бэлдэх, суурин дээр байрлуулан боох, бэхлэх.	ш	8			
32	Тухайн өндөрлөсөн хэсэгт Ф325мм фланц шинээр хийх, жийрэг тавьж боох.	ш	1			
33	Засварын хогуудыг цэвэрлэж зайлуулах	ком	1			


**ҮНСНИЙ 3 ДУГААР ШУГАМ ИХ ЗАСВАР ХИЙХЭД ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

№	Материал, сэлбэгийн нэрс	Хэмжих нэгж	Нийт тоо хэмжээ	Материалын марк, типа
1	Кислород	М <sup>3</sup>	200	
2	Пропан хий	кг	80	
3	Электрод УОНИ 13/55	кг	150	
4	АНО /хятад/	кг	40	
5	Огтлогч чулуу	ш	20	
6	Өнгөлөгч чулуу	ш	40	
7	Полоса төмөр б-4мм	тн	0.1	
8	Бөөрөнхий төмөр Ф12-20мм	тн	0.15	
9	Швеллерь Н=140-160	тн	0.5	
10	Боолт, гайка М12-24	ш	24	L=300мм зургийн дагуу зоруулах
11	Тосон сальник Ф16-20мм	кг	20	
12	Солярка /Кран, Сак/	л	1729	сак-141 мот/цаг, кран- 94 мот/цаг
13	Арчих материал	кг	20	
14	Техникийн резин	кг	30	
15	Боолт, гайка М14 L=100	ш	170	
16	Труба Ф325x10мм	тн	4,7	
17	Булан 120 <sup>0</sup> Ф325x10мм,	ш	4	


Жич:Тавигдсан дээрх жагсаалт нь зайлшгүй нийлүүлж хийгдэх сэлбэг материал бөгөөд ажил гүйцэтгэхэд шаардагдах кран, сак, ковш тэдгээрт хэрэглэгдэх шатхуун болон бусад материал /арчих материал, электрод, кислород, таслах, өнгөлөх материалууд, болон бусад шаардлагатай материал/-ыг ажлын эзэлхүүнээс тооцон хүрэлцэхүйц хэмжээгээр төсөвлөн, үнэлж ирүүлнэ.



ДДС-н үнсний шугам №2,3  
/Хашаан доторхи хэсэг/



ДДС-н үнсний шугам №2,3  
/Хашааны гадна хэсэг/



## Зургаа. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга ..... танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
  2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
  3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
  4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.  
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
  5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
  6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.  
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
  8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
  9. **Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт,** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил,

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

<b>засвар, үйлчилгээний гарын авлага</b>	инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
	17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
<b>18. Гэрээг цуцлах</b>	18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
	18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: <ul style="list-style-type: none"> <li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li> <li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;</li> <li>(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;</li> <li>(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</li> <li>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</li> </ul>
	18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
<b>19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр</b>	19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
	19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
<b>20. Гүйцэтгэлээс чөлөөлөх</b>	20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа

ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

найм. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Үнсний 3 дугаар шугам их засвар хийх. ЗХА-08. 2020</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь: <i>Үнсний 3 дугаар шугам их засвар хийх</i> Ажлын талбай: <i>ДДЗЦехийн БАА-гаас үнсэн сангийн хооронд байрлана.</i>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер: <i>ЗХА-ны дунд даралтын хэсгийн зуухны засвар хяналтын инженер Ш.Мөнхцог</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: <i>2020 оны 06-р сарын 15</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <i>2020 оны 08-р сарын 15</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>180</i> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>0,3%</i> байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>30%</i> -иас байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага <i>шаардлагагүй</i>  Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

БАТЛАВ:  
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

БАТЛАВ:  
..... ХХК-ИЙН ЗАХИРАЛ

..... /

/

..... /

/

### ҮНСНИЙ 3-Р ШУГАМЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны .... -р сарын . . .-ны өдөр №.....

Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-3” ТӨХК-г төлөөлж Тэргүүн дэд захирал, Ерөнхий инженер ..... /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас “.....” ХХК-ийг төлөөлж Ерөнхий инженер ..... /цаашид “гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, “ДЦС-3” ТӨХК-ийн Үнэлгээний хорооны 2020 оны ....-р сарын .....-ны өдрийн ..... тоот хурлын шийдвэр, Үнэлгээний хорооны ..... тоот зөвлөмжийг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

#### ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

“Үнсний 3-р шугамын их засвар”-ын ажлыг тендерийн баримт бичигт заасан шалгаруулалт, шаардлагад нийцүүлэн графикт хугацаанд чанартай, технологийн дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

#### НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “Үнсний 3-р шугамын их засвар”-ын ажлыг 2020 оны ....-р сарын ....-наас 2020 оны ....-р сарын ....-ний хооронд багтаан хийж хүлээлгэн өгнө.

1.2. Гэрээт ажлын үнэ Үнэлгээний хорооны ..... тоот зөвлөмжийн дагуу НӨАТ, материал, тээвэр болон бусад бүх зардлыг тооцоод ..... төгрөг байна.

1.3. Урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд ажил бүрэн гүйцэтгэж захиалагч талд хүлээлгэн өгч гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш хуанлийн 30 хоногт багтаан гэрээний үнийн дүнгийн 90% буюу .....-н төгрөгийг олгоно.

1.4 Гэрээт ажлын баталгаат хугацааны 10% буюу .....төгрөгийг хурлын тэмдэглэлийг үндэслэн олгоно.

#### ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээн авч санхүүжилтийг гэрээ дүгнэсэн акт болон нэхэмжлэлийг үндэслэн хийж гүйцэтгэнэ.

2.2. Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд комисс гарган хүлээн авна.

2.3. Баталгаат хугацаа хүлээлгэн өгснөөс хойш 3 сар байна. Гэрээт ажлын баталгаат хугацаа дууссаны дараа баталгаат хугацааны барьцааны 10%-г олгох хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

2.4. Баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

2.5. Захиалагч нь засварт хэрэглэгдэх сэлбэг материалын чанар, зарцуулалтанд хөндлөнгийн хяналт тавьж үлдэгдэл материалыг буцаан гаргах зөвшөөрөл олгоно.

<sup>5</sup>Гэрээ байгуулах үед үүнийг хасна.



### **ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Засварыг гэрээнд заасан хугацаанд технологийн дагуу чанартай хийж хүлээлгэн өгнө.

3.2. Станцын горим, ажиллагаанаас хамааран эхлэх хугацаанд өөрчлөлт орж болох ба узель зангилаа бүрийн ажлыг хэсэгчлэн гүйцэтгэнэ.

3.3. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай сэлбэг, материалыг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуулд бүртгүүлэн, эрх бүхий албан тушаалтнуудын хяналтаар нэвтрүүлнэ. Хэрэглэсэн материал сэлбэгийн зарцуулалтыг захиалагчид тайлагнах, төсөвт тусгагдсан үлдэгдэл материалыг ажил гүйцэтгэж дууссаны дараа захиалагчид шилжүүлэх үүрэгтэй.

3.4. “Үнсний 3-р шугамын их засвар”-ын ажилтай хобогдолтой техникийн бичиг баримтыг бүрдүүлэх.

3.5. Засварын ажил нь чанарын шаардлага хангахгүй тохиолдолд гүйцэтгэгч хугацаа алдалгүй өөрийн хүчээр хийж өгөх ба гарсан бүх зардлыг хариуцна.

3.6. Засварын хугацаанд ХАБЭА-н болон бусад аюулгүй ажиллагааны бүх арга хэмжээг бүрэн хариуцаж ажиллана.

3.7. Засварын баталгаат хугацаанд гэрээт ажлын хөлсний 10%-ийг захиалагчийн дансанд байршуулна.

### **ДӨРӨВ. ГЭРЭЭ ДҮГНЭЖ ХАРИУЦЛАГА ТООЦОХ**

4.1 “Үнсний 3-р шугамын их засвар”-ын ажлыг бүрэн дуусгаж техникийн бичиг баримт бүрдэлтийг хийж захиалагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнэнэ.

4.2. Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

4.3. Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

### **ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

5.1. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, гал түймэр, үер, шуурга, газар хөдлөлт, дайн, эдийн засгийн болон импортын шууд хориг, энэ гэрээг баталсны дараа үүсч болзошгүй онцгой байдалд хүргэсэн бусад нөхцлүүд гэрээг биелүүлэхэд саад учруулсан зүйлүүд орно.

5.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас шууд шалтгаалан энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүхлээр нь биелүүлэхгүйд хүрсэн бол талууд хариуцлагыг хүлээхгүй.

5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 7 хоногийн дотор гэрээний үүргээ биелүүлэх бололцоогүй болсон тал нь нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

5.4. Хэрэв давагдашгүй хүчин зүйлс гэрээний биелэлтэнд 1 сарын турш үйлчлэх тохиолдолд үүргээ биелүүлж чадахгүй болсон тал цаашид энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд талууд гэрээг хүчингүй болсон хугацаагаар ажлын гүйцэтгэлийн тооцоог дуусгана.

### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

6.1. Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.

6.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж талууд захиалагч 3%, гүйцэтгэгч 1%-ийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.

6.4. Талууд аль нэг нь гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар нь тодорхой хариу өгнө.

6.5. Талууд энэхүү гэрээгээр тохиролцсон үйлчлэх хүрээ, цаг хугацаа, нөхцөлийг дур мэдэн өрчлөх эрх эдлэхгүй.

6.6. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ДОЛОО. ТАЛУУДЫН ХАЯГ:**

**ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:**

Хаяг: Хан –Уул дүүрэг. 3-р хороо  
“ДЦС–3” ТӨХК-ийн байр  
Утас: 11–343024  
Факс: 70043024

**ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХАЯГ:**

.....  
.....  
Утас: .....  
Данс: .....  
РД: .....

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :**

“ДЦС-3” ТӨХК–ийн Тэргүүн дэд  
захирал, ерөнхий инженер  
..... / .....

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :**

“.....” ХХК-ийн  
инженер  
..... / .....

ЗХА –ны дарга

..... / .....

СБХ –ийн дарга

..... / .....

Ерөнхий нягтлан бодогч

..... / .....

ДДЗЦ-ийн дарга

..... / .....

Гэрээний мэргэжилтэн

..... / .....

Хянасан:

Хуулийн мэргэжилтэн

..... / .....